



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулинд заасан хэмжээнд хүрээгүй байна.

Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар 3
Баян-Өлгий аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Бекен	Бүлэг 1 Аймгийн ИТХ, Засаг дарга нь байгаль орчныг хамгаалах талаар хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна. 6-13
Аудитын менежер Х.Женисбек	1.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд орон нутгийн төсвөөс жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө төлөвлөн, зарцуулж ирсэн байна.
Ахлах шинжээч К.Риза	1.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд тодорхой ажлууд хийгджээ.
Шинжээч Ж.Назгүл	Бүлэг 2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн байна 13-14
2016 оны 10 дугаар сар	2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж чадаагүй байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу	2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө жил бүр давж биелэгдсэн байна.
ХАЯГ:	Бүлэг 3 2015 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулийн заалтыг хангахгүй байна. 15-17
Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 102, 106 тоот өрөө	3.1. Сумууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг урсгал зардалд зарцуулж хуулийн заалтыг зөрчиж байна
	3.2 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр журамд заасан зориулалтын дагуу зарцуулжээ
	3.3 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгө нь хуулинд заасан хувь хэмжээг хангахгүй байна
	3.4 Ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулийн заалтыг хангахгүй байна
	3.5 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлжээ
	Бүлэг 4 Ус ашиглуулахтай холбоотой хяналтыг сайжруулах шаардлагатай байна 18-19
	4.1 Байгаль хамгаалах хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх зүйн орчин бүрдсэн байна.
	4.2 Ус ашиглуулахтай холбоотой хяналтыг сайжруулах шаардлагатай
	Дүгнэлт 20
	Зөвлөмж: 21
	Холбогдох байгууллагын санал: 22
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БОХС	Байгаль орчныг хамгаалах сан
БОС	Байгаль орчны сан
МАНУТХГХЗ	Монгол Алтайн Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай Газруудын Хамгаалалтын Захиргаа
ААН	Аж ахуйн нэгж

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд нийцлийн аудит хийж, гарсан зөрчил, дутагдлуудыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Аймгийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх
- Байгалийн хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Байгаль орчныг хамгаалах талаар гарсан хууль тогтоомж, аймгийн ИТХ, Засаг даргаас гарсан шийдвэр, ажлын тайлан, БОАЖГазар, Сум дундын ойн анги, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, мэдээ, хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийн тайлан, тооцоо судалгаануудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг АДБОУС 100-400, 3000, 3100, 4000, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аймгийн БОАЖГазар, Сум дундын ойн анги болон МХГазрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, тайлбар лавлагаа авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Усны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Амьтаны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”*
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан *“Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”*
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Үндсэн мэдээлэл

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2014 онд аймгийн БОХСангаас 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 82,6 сая төгрөгийн төсөв батлан хэрэгжүүлсэн байна. Байгаль орчныг хамгаалах сангаас нөхөн сэргээлтэнд зарцуулах хөрөнгийг 2015 онд 61,1 сая төгрөгөөр, 2016 онд 59.2 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Бүлэг 1

Аймгийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.

Оршил

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгалийн унаган төрхийг хадгалах зорилгоор газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар зэрэг объектуудыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь байгалийн дээрхи объектуудын тухай болон тэдгээрийг хамгаалахтай холбогдон гарсан хууль тогтоомжуудаас бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд аймаг, сумын ИТХ, баг, хорооны иргэдийн Нийтийн хурал болон Засаг даргын нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв батлах, биелэлтэнд хяналт тавих, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх бүрэн эрхийг тодорхойлсон байна.

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд хяналт тавих мэргэжлийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг мөн байгаль орчин, байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн байгууллагын чиг үүргийг дээрхи хуулиар зохицуулжээ.

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд заасан бүрэн эрхийн хүрээнд Аймгийн ИТХ, Засаг даргаас хийж хэрэгжүүлсэн ажлын талаар.

1.2. Аймгийн ИТХурлын байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэнд хяналт тавих бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд орон нутгийн төсвөөс жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө төлөвлөн, зарцуулж ирсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1 дэхь хэсэгт заасан аймгийн ИТХурлын бүрэн эрхийн хүрээнд нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан сүүлийн 3 жилд орон нутгийн төсөв, ОНХСангийн хөрөнгөнөөс тодорхой хэмжээний хөрөнгө хуваарилан баталж, хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

-2014 онд аймгийн БОХСангаас 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 82,6 сая төгрөгийн, ОНХС-ийн хөрөнгөнөөс ойжуулалтын ажилд 150,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төсөв баталж, тогтоол гаргажээ.

Үүнээс гадна аймгийн ИТХ-ын тогтоолоор 2014 онд үр суулгац бэлтгэхэд зориулан Орон нутгийн орлогын давсан хэсгээс 10,0 сая төгрөгийг Сум дундын ойн ангид эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон байна.

-Аймгийн ИТХурлын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор Байгаль орчныг хамгаалах сангаас 2015 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 80.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд ИТХурлын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 53 тоот тогтоолоор 18,9 сая төгрөгөөр бууруулан 61,1 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

- Байгаль орчныг хамгаалах санд 2016 онд хуваарилах хөрөнгийг аймгийн ИТХурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 63 тоот тогтоолоор 59.2 сая төгрөгөөр баталсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд тухайн нутаг дэвсгэрээс ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийн дээд хэмжээг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор тогтоож, газар нутгийн нэрээр зааж баталсан байна.

Тухайлбал: 2014 онд 4600 м.куб, 2015 онд 10260 м.куб, 2016 онд 13270 м.куб түлээ бэлтгэхээр ой бүхий сумдад хуваарилж, Толбо нуураас 2014 онд 10 тонн, 2015 онд 20 тн, 2016 онд ахуйн зориулалтаар 2000 ширхэг загас агнахаар тус тус хязгаар тогтоосон байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 68 тоот тогтоолоор байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдлоор нь газар нутгийг хамгаалах байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор амьтан, ургамал, усны нөөц, газрын ангиллаар 44213,1 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч хилийн зааг тогтоосон байна.

2014 онд БОАЖГазрын даргын “Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах” сэдэвт сонсголыг, 2015 онд аймгийн Хүн амын ундны усны хангамж, чанар, аюулгүй байдлын талаар хэрэгжүүлж байгаа Усны тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаар Өлгий сумын Засаг даргын сонсголыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хурлаар авч хэлэлцжээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.6-д “шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна” гэж заасан боловч нөөцийн санг хүлээлгэн өгсөн, сангийн өөрчлөлтийн тайланг авч хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй ирсэн байна.

1.3. Аймгийн Засаг даргын байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн ажлын талаар.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд тодорхой ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд жил бүр БОХСангийн хөрөнгөөр хэрэгжих байгалийг нөхөн сэргээх арга хэмжээ болон аймгийн нутаг дэвсгэрээс ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын дээд хэмжээг сумын нэрээр гаргаж ИТХуралд өргөн мэдүүлэн хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ажлуудыг тоймлон авч үзвэл:

- 2014 онд Орон нутгийн төсвөөс БОХСанд хуваариласан хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 82,6 сая төгрөгийн өртөг бүхий 8 арга хэмжээний 71,6 сая төгрөгийн санхүүжилтийг БОАЖГазраар дамжуулан, Сум дундын ойн ангид 11,0 сая төгрөгийг олгож зориулалтын дагуу зарцуулжээ.Тухайлбал:

БОХСангаас БОАЖГазарт хуваариласан хөрөнгөөр “Анчдын нийгэмлэг” ТББайгуулага аймгийн ан, агнуурын менежментийн төлөвлөгөөг 35.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, ан, амьтныг хамгаалах, ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

Сум дундын ойн анги ойн зурвас байгуулах ажлын хүрээнд “Буыршын” ХХК-тай 2.2 сая төгрөгийн, “Тазалык” ХХК-тай 3.3 сая төгрөгийн, “Айтуар” ХХК-тай 4.4 сая төгрөгийн нийтдээ 9 га газарт 9.9 сая төгрөгийн ойжуулалтын ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

Мөн “Айтуар” ХХКомпани мод үржүүлгийн талбайг өргөтгөх ажлыг 6.0 сая төгрөгөөр, “Софтвермейнт” ХХКомпани мод үржүүлэх, хүлэмж авах ажлыг 6.8 сая төгрөгөөр, “ПГЖМ” ХХКомпани байгаль хамгаалагч нарын албаны хэрэгцээнд зориулан мотоцикл, зургийн аппарат, компьютер, GPS зэрэг 9,9 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлж, “Өмир агаш крафт” ХХКомпани булгийн эх хамгаалах ажлыг 4.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Байгаль орчныг хамгаалах сангаас Сум дундын Ойн ангид хуваариласан хөрөнгөөр Толбо чиглэлийн хар замын дагуу 10 га талбайд “Ногоон хэрэм”-ийн туслах зурвас байгуулах ажлыг “Буыршын” ХХК 11.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, 10 га-д 6000 ширхэг улиас, бургас, хайлаас зэрэг модны суулгац тарьж, хашаа хамгаалалтыг хийжээ.

ОНХСангаас Ховд голын эрэг орчим ойн зурвас байгуулах, хашаа татахад зориулан хуваарилагдсан 150,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Ховд-Сафари” ХХКомпани ойн зурвас байгуулах, хашаа татах ажлыг гүйцэтгэн 15000 ширхэг мод тарьж хүлээлгэн өгсөн байна.

Дээрхи ажлуудын үр дүнд 2014 онд аймгийн хэмжээнд нийтдээ 51514 ширхэг мод таригдаж, ойжуулалт, ойн зурвасуудыг улсын комисс хүлээж авч акт материалуудыг холбогдох газруудад хүргүүлжээ.

- 2015 онд БОХСанд хуваарилсан хөрөнгөнөөс 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 58.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

“Ногоон хэрэм”-ийн болон Өлгий сумын хүүхэд залуучуудын парк зэрэг өмнөх жилүүдэд хийгдсэн ойжуулалтын ажлын усалгаа арчилгааны ажлын хүрээнд гүн өрмийн 5 худаг гаргах ажлыг “Мөлдир су” ХХКомпани 16,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн, ургамал ногоо усжуулахад ашиглаж байна.

Өлгий сумын Хар толгойн мод үржүүлгийн талбайд “Ногоон хэрэм” зурвасын дагуу ойн зурвас байгуулах ажлыг 3.5 сая төгрөгөөр сум дундын Ойн анги хийж гүйцэтгэн 2100 ш мод тарьж улсын комисст хүлээлгэн өгчээ.

Толбо сумын чиглэлийн хар замын дагуу ойн зурваст усалгаа хийхэд шаардагдах цахилгааны эх үүсвэрийг “Сагсай шугам” ХХК 16.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд өгсөн байна.

Алтай сумын Даваат, Хүйтэн оргил, Толбо сумын Борт уул, Бугат сумын Хатуугийн эх зэрэг газруудад зэрлэг ан амьтанд зориулан 2.0 сая төгрөгийн хужир, давс тавьж биотехникийн арга хэмжээ авч, Улаанхус сумын Хүрэн уулын булаг, Бугат сумын Хатуугийн булаг шандыг хашиж хамгаалах ажилд 2,8 сая төгрөг зарцуулжээ.

Байгалийн ховор ургамал зэрлэг сармисны нөөцийг тогтоож, нөхөн сэргээх, нутагшуулах, тармилжуулах зорилгоор Алтай сумын Ёлтод 1 га газарт зэрлэг сармис, 1.3 га газарт алтайн сонгиныг үрээр нь тарих ажлыг 0.7 сая төгрөгөөр “Сауран” ХХКомпани хийсэн байна.

Суулгацаар ойжуулах төслийн 2.3 сая төгрөгөөр “Орман-ан” ХХКомпани Цэнгэл сумын Хара татыр гэдэг газарт 5 га талбайд 1500 ш таримал мод суулгаж, ойн байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын хүрээнд Цэнгэл сумын “Хулан” нөхөрлөл 5 га, Баяннуур сумын “Дэмжих толгой” нөхөрлөл 10 га, “Зааг” нөхөрлөл 5 га, “Избасар” нөхөрлөл 10 га газрыг мал амьтнаас хашиж хамгаалах ажлыг 5.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэжээ.

Аймгийн төвөөс Толбо, Алтанцөгц, Улаанхус, Сагсай, Хотгорын гарах 5 чиглэлийн дагуу 9.8 сая төгрөгөөр байгаль хамгаалах сурталчилгааны самбар хийж байрлуулсан байна.

- 2016 онд БОХСангаас 50 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсаны дагуу 5.0 сая төгрөгийн ан амьтанд хужир давс тавьж биотехникийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн ба үлдсэн 4 арга хэмжээ нь одоогийн байдлаар хэрэгжих шатандаа байна.

Аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс байгаль орчныг хамгаалах талаарх хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлэн ажиллажээ.

Байгаль хамгаалах тухай хуулинд заасан аймгийн ИТХурлын дарга болон Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, баялагийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах,

байгууллагын байгаль орчинд нөлөөлж буй үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоох арга хэмжээ авч ажилласан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт заасан аймгийн ИТХурлын бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ-ын дэргэд Байгаль орчин, соёл спорт аялал жуулчлалын хороог ажиллуулан уг хорооноос санаачлан жил бүр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах нөхөн сэргээхтэй холбогдсон орон нутагт нэн тулгамдсан асуудлуудыг аймгийн ИТХ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд тусган холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангуулж ирсэн байна.

- 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан аймгийн МХГазар, Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар, Татварын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөлтэй ИТХ-ын даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг уул уурхайн хайгуул, олборлолт явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт явуулсан байна.

Шалгалтаар Ногооннуур сумын нутагт хамгаалалтгүй орхисон 2 орд газарт иргэд хууль бусаар олборлолт хийж газрыг эвдсэн, Алтай сумын Хөхсүнгийн орчны хайгуулын талбайгаас хууль бусаар алт олборлож байсан 3 карьерт нөхөн сэргээлт хийгдээгүй зэрэг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой зөрчлүүд илэрч холбогдох байгууллагуудад арилгуулахаар чиглэл өгөгдөн хэрэгжилтийг хангуулжээ.

Мөн аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг ажиллуулж аймгийн хэмжээнд ашигт малтмалын лицензтэй үйл ажиллагаа эрхлэх 9 компаний орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж, хандив тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг хийсэн байна.

- 2015 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 30 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хариуцлагыг сайжруулах зорилгоор Байгаль орчин, соёл, спорт, аялал жуулчлалын ажлын хэсэг байгуулан ажиллуулан уг ажлын хэсгээс аймгийн ЗДТГазар, МХГазар, Байгаль орчны газар, МАНУТХГХЗахиргаа зэрэг байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг бүх сумыг хамруулан үзлэг шалгалт явуулжээ.

Хяналт шалгалтын үр дүнгээр ус ашиглагч зарим байгууллага тоолуургүй ус ашиглаж байсан, усны төлбөр, ногдуулалт, төлөлт тодорхойгүй, Өлгий, Бугат сумдын төвийн зарим иргэн, аж ахуйн нэгж байгууллага Ховд голын онцгой болон энгийн хамгаалалттай бүсээс хайрга олборлож байсан, ОХУ-аас аялал жуулчлалаар ирсэн иргэд зөвшөөрөлгүй загасчилж байсан зэрэг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах талаарх зөрчлүүд гарч байгаад дүгнэлт хийж, зөрчил гарсан сумдын байгаль хамгаалагч, улсын байцаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон байна.

2014 онд аймгийн Засаг даргын шийдвэрээр агаарын бохирдолын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж, явуулсан ажлын хэрэгжилтийг мэргэжлийн байгууллагаар хангуулжээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2013 оноос эхлэн жил бүр аймгийн төвд мод суулгацны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээний болон мод тарих өдрийг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.

Байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж болон байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудыг талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, өдөрлөг зохион байгуулах, сургуулийн сурагчдын дунд сурталчилгаа таниулга хийх хэлбэрээр явуулсан байна.

2014 онд Амьтны тухай хуулийн дагуу Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, Толбо нуурт загасны нөөц тогтоох ажлуудыг эрх бүхий байгууллагуудаар хийлгэсэн байна.

Аймгийн хэмжээнд уст цэгийн нэгдсэн тооллогыг Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 4 жилд нэг удаа хийж байгаа ба уст цэгийн тооллогыг сүүлийн удаа 2015 онд хийжээ. Сумууд уст цэгийн тооллогыг жил бүр хийж мэдээ тайланг БОАЖГ-т ирүүлсэн байна.

Нэгдсэн тооллогоор 131 гүн өрмийн худаг, 1838 гар худаг, 369 гол, горхи, 1220 нуур, тойром, 861 булаг шанд, 31 рашаан, мөсөн гол 128, усан сан, хөв цөөрөм 2, услалтын систем 16, цэвэрлэх байгууламж 1 тус тус тоологдсон байна.

-Орчны бохирдлын түвшний судалгаагаар азотын давхар исэл 2014 онд 34, 2015 онд 30 удаа зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан тохиолдол гарч бохирдлын түвшин жил бүр нэмэгдсэн байна.

Агаарын бохирдлын түвшин нэмэгдэхэд ашиглалтын хугацаа дууссан хуучин машин техникийн тоо нэмэгдсэн, төвийн нэгдсэн халаалтын системд холбогдоогүй аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн хэрэгцээнд, айл өрх ахуйн хэрэгцээнд түүхий нүүрс хэрэглэдэг, ахуйн хог хаягдлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Орчны бохирдлын эх үүсвэрийн тооллогоор 2014 онд аймгийн төвд ердийн галлагатай 10 квт хүчин чадалтай зуухны тоо 9754, усан халаалтын 11 квт-100 квт хүчин чадалтай зуухны тоо 234, Дулааны цахилгаан станцын 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо 4 байгаа ба нэг жилд 85987,1 мянган тонн нүүрс хэрэглэсэн тооцоо гарчээ.

2015 онд аймгийн төвд ердийн галлагатай 10 квт хүчин чадалтай зуухны тоо 9817, усан халаалтын 11 квт-100 квт хүчин чадалтай зуухны тоо 410, Дулааны цахилгаан станцын 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо 4 тооллогдож нэг жилд 97833,1 мянган тонн нүүрс хэрэглэсэн тооцоо гарчээ.

Дулааны станцын нэгдсэн шугам сүлжээгээр халаалт өгч байгаа төвлөрсөн зуухны хүчин чадал аймгийн төвийн бүх хэрэглэгчдийг дулаанаар хангах техникийн нөхцөл боломж байхгүйгээс нэгдсэн шугам шүлжээнд холбогдоогүй нам даралтын зуух ашиглах ААНэгж, айл өрхийн тоо жил бүр нэмэгдэж байгаа нь түүхий нүүрсний хэрэглээ өсөхөд нөлөөлж байна. Энэ нь агаар дахь хорт утааны

хувийн жин өсч иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихсэхэд хүргэж байна.

Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж заасан боловч хууль гарахаас өмнө ашиглалтанд орсон дулааны цахилгаан станцын 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухнуудад дүгнэлт гараагүй байна.

-Аймгийн төвд механик-биологийн ажиллагаатай цэвэрлэх байгууламж нь 1986 онд ашиглалтанд орсон байна. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 2001-2002 онд бохир усыг байгалийн биологийн аргаар цэвэрлэх Швед улсын технологиор өөрчлөн барьж цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын хашааг өргөтгөж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөтгөл хийж 7 цөөрөм нэмж барьсан байна.

Уг цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал нь бохир усны цэвэрлэх байгууламж биш бохир ус хуримтлуулах талбай болон хувирч, хэрэв цөөрөм задарвал Ховд голд цутгаж бохирдуулах бодит аюул тулгарч байна.

Аймаг орон нутгаас 2008 оноос хойш шинээр механик-биологийн ажиллагаатай цэвэрлэх байгууламж барих асуудлыг холбогдох газруудад тавьж зураг төсөв хийлгэсэн боловч төсөв хөрөнгө нь шийдэгдээгүй байна.



Цэвэрлэх байгууламж



Аймгийн төвийн Хогийн цэг

Аймгийн төвд хог хаягдлын цэгийг 2012 онд ландфилийн аргаар 2 жилийн хугацаатайгаар барьж байгуулсан боловч уг цэгийн ашиглалтын хугацаа дуусч шинээр хог хаягдлын цэг байгуулах шаардлагатай болсон байна.

-Тус аймагт ойн нөхөрлөл 28, ангийн нөхөрлөл 18, бэлчээр хамгаалах нөхөрлөл 2 бүгд 48 нөхөрлөл БОСайдын 2006 оны 114 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг байна.

БОАЖГазар эдгээр нөхөрлөлүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байгаа боловч орон нутгаас нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв батлах, санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны мэдээ тайланг нэгтгэн, байгаль хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр ИТХ-аар хэлэлцүүлэх зэрэг хуулинд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих ажлууд хангалтгүй хэрэгжсэн байна.

Бүлэг 2

*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг
төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.*

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын талаар.

2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой эсэх талаар.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж чадаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 30 дугаар тогтоолоор 2014 онд орон нутгийн төсвийн орлогод түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогоос 9,6 сая төгрөгийн, ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 2,7 сая төгрөгийн, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 37,6 сая төгрөгийн, ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 27,1 сая төгрөгийн нийтдээ 77,0 сая төгрөгийн орлого оруулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 62 тоот тогтоолоор 2015 онд орон нутгийн төсвийн орлогод түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогоос 32,0 сая төгрөгийн, ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 48,0 сая төгрөгийн, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 37,6 сая төгрөгийн, ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 30.0 сая төгрөгийн нийтдээ 147,6 сая төгрөгийн орлого оруулахаар баталжээ.

2015 онд ус ашигласны төлбөр, газрын нөөц ашигласны төлбөрийг нэмж төлөвлөсөнөөр байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого өмнөх оноос 70,6 сая төгрөгөөр нэмэгджээ.

- 2014 онд Ховд голын сав газрын захиргаанаас 3, БОАЖГазраас -1 нийтдээ 4 аж ахуйн нэгжид, Ховд голын сав газрын захиргаанаас 2015 онд 4 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан байна.

Энэхүү ус ашиглуулах дүгнэлтийн дагуу ус ашигласны төлбөрөөс 2014 онд 172,0 сая төгрөгийн, 2015 онд 16,9 сая төгрөгийн орлого оруулах тооцоо гарч байгаа боловч эдгээр орлогыг тухайн жилийн төсвийн орлогын төлөвлөгөө боловсруулахад үндэслэл болгоогүй байна.

-Ангийн нөөц ашигласны орлогын төлөвлөгөөг тухайн жилд агнах ангийн тоо толгойг үндэслэн төлөвлөөгүй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/426 тоот тушаалаар тус аймагт 2015 онд агнах ангийн зөвшөөрлийг тоо толгой, сумын нэрээр нь баталсан боловч уг зөвшөөрөл аймгийн ИТХ-аас 2015

оны төсвийг батлагдсаны дараа ирсэнээс тухайн жилийн орлогын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

-Ойн нөөц ашигласны төлбөрийг жил бүрийн ойгоос ашиглах түлээний модны дээд хэмжээг үндэслэн төлөвлөжээ.

Дээрхи байдлаар байгалийн зарим төрлийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухайн жилд ашиглах нөөцийн хэмжээтэй уялдуулж төлөвлөгөөгүйгээс орлогын төлөвлөгөөний биелэлт хэт их хэлбэлзэлтэй байдаг байна.

2.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн эсэх талаар.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө жил бүр давж биелэгдсэн байна.

Татварын хэлтсийн мэдээ тайлангаар байгалийн нөөц ашигласны орлогоос 2014 онд 77.0 сая төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 105.3 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 28.3 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл газрын нөөц ашигласны төлбөрийн орлого 10.6 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 35.0 сая төгрөгөөр давж, ан, амьтны нөөц ашигласны төлбөр 16.2 сая төгрөгөөр, Ойн нөөц ашигласны төлбөр 1,1 сая төгрөгөөр тасалдсан байна.

2015 онд 147.6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 377.1 сая төгрөгийн орлого оруулж 229,5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 276.5 сая төгрөгөөр давж биелэгдэж бусад төрлийн орлого тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хоёр жилийн судалгааг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

№	Байгалын нөөц ашигласны төлбөрийн нэр	2014 он			2015 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ургамалын нөөц ашигласны төлбөр	0	0	0	0	1,4	1,4
2	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2,7	37,7	35,0	48,0	16,4	-31,6
3	Ойн нөөц ашигласны төлбөр	37,6	36,5	-1,1	37,6	28,1	-9,5
4	Ан, амьтаны нөөц ашигласны төлбөр	27,1	10,9	-16,2	30,0	306,5	276,5
5	Газрын нөөц ашигласны төлбөрийн орлого	9,6	20,2	10,6	32,0	24,7	-7,3
	Нийт дүн	77,0	105,3	28,3	147,6	377,1	229,5

Бүлэг 3

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулинд заасан хувь хэмжээг хангахгүй байна.

3.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжтой нийцсэн эсэх талаар.

3.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаар тогтоож мөрдсөн эсэх талаар.

Сумууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төсвийн урсгал зардалд зарцуулж хуулийн заалтыг зөрчиж ирсэн байна.

-Тус аймгийн орон нутгийн төсөвт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд нийтдээ 105.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хувь хэмжээгээр тооцож үзэхэд 52.7 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах тооцоо гарч байна.

Тухайн онд байгаль хамгаалах сангаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 82.6 сая төгрөгийг зарцуулж хуулийн хэрэгжилт 156.7 хувийн биелэлттэй гарч байна.

-2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос нийтдээ 377.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн ба Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож үзэхэд нийтдээ 186.8 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах тооцоо гарч байна.БОХСангаар дамжуулан орон нутгийн төсвөөс 58.9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, хуулийн хэрэгжилт 31.5 хувьтай хэрэгжсэн байна.

Харин сумууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуулинд заасан хувь хэмжээгээр хөрөнгө төвлөрүүлэхгүйгээр төсвийн урсгал зардалд зарцуулж ирсэн байна.Үүнийг сум бүрээр авч үзвэл:

2015 онд Алтай сум 1,0 сая төгрөгийг, Алтанцөгц сум 1,8 сая төгрөгийг, Буянт сум 35,5 сая төгрөгийг, Булган сум 38,6 сая төгрөгийг, Бугат сум 21,0 сая төгрөгийг, Баяннуур 2,4 сая төгрөгийг, Ногооннуур 3,6 сая төгрөгийг, Сагсай 2,7 сая төгрөгийг, Цэнгэл сум 11,7 сая төгрөгийг, Дэлүүн 37,2 сая төгрөгийг, Улаанхус 19,0 сая төгрөгийг, Толбо сум 9,4 сая төгрөгийг, Өлгий сум 2,9 сая төгрөгийг нийтдээ 186,8 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.1-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны ИТХ-аар батлуулна” гэж заасан боловч хуулийн энэ заалт сумдад хэрэгжээгүй байна.

Дээрхи байдлаас дүгнэлт хийж үзэхэд сумдын төсвийн орлогод төвлөрсөн байгаа байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулинд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар хөрөнгийн хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байгаа ба хуулийн энэ заалт хэрэгжиж буй эсэхэд холбогдорх байгууллагууд нь хяналт тавиагүй байна.

Харин аймгийн төсвөөс БОХСанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд жил бүр зохих хэмжээний хөрөнгө төлөвлөн зарцуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014-2015 онуудад зарцуулсан хөрөнгийн хэмжээг хүснэгтээр нэгтгэн харуулвал: /сая төгрөгөөр/

№	Байгалын нөөц ашигласны төлбөрийн нэр	2014 он					2015 он				
		Орлогын төрөл	Хуулиар зарцуулах хувь хэмжээ	Хуулийн дагуу нөхөн сэргээлтэнд зарцуулах хэмжээ	Нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Зөрүү	Орлогын төрөл	Хуулиар зарцуулах хувь хэмжээ р	Хуулийндагуу нөхөн сэргээлтэнд зарцуулах хэмжээ	Нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Зөрүү
1	Ургамалын нөөц ашигласны төлбөр	0	15%	0.0	0	0.0	1.4	15%	0.2	0.7	0.5
2	Ойн нөөц ашигласны төлбөр	36.5	85%	31.0	33.7	2.7	28.1	85%	23.9	44.2	20.3
3	Ус рашаан ашигласны төлбөр	37.8	35%	13.2	4.0	-9.2	16.4	35%	5.7	2.8	-2.9
4	Ан, амьтаны нөөц ашигласны төлбөр	10.8	50%	5.4	35.0	29.6	306.5	50%	153.3	1.2	-152.1
5	Түгээмэл тархацын нөөц ашигласны төлбөр	20.2	15%	3.0	0	3.0	24.7	15%	3.7	0	.7
	Байгаль хамгаалагчдыг техник хэрэгслээр хангах				9.9						

	Сурталчилгааны самбар хийх									10.0	
	Дүн	105.4		52.7	82.6	20.0	377.1		186.8	58.9	137.9

3.2. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээнд зарцуулсан эсэх талаар.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр журамд заасан зориулалтын дагуу зарцуулжээ.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 36.5 сая төгрөгийн орлого орсон ба Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээгээр 31.0 сая төгрөгийг ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээнд зарцуулах ёстойгоос тухайн онд 33.7 сая төгрөгийг зарцуулж хуулийн биелэлт 108.7 хувьтай байна. Сум дундын ойн анги ойн зурвас байгуулах ажлын хүрээнд "Буыршын", "Тазалык", "Айтуар" ХХКомпани зэрэг ойн мэрэгжлийн ААН-үүдээр гүйцэтгүүлсэн ойжуулалтын ажилд 22,7 сая төгрөг, ойн зурвас байгуулах ажилд 11,0 сая төгрөг тус тус зарцуулж Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээнд зарцуулсан байна.

2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 28.1 сая төгрөгийн орлого орсоны 23.9 сая төгрөгийг ойг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ёстойгоос 44.2 сая төгрөгийг зарцуулж, хуулийн хэрэгжилт 184.9 хувийн биелэлттэй гарч байна. Үүнд: "Ногоон хэрэм" ажлын хүрээнд ойжуулалтын ажилд 19,5 сая төгрөгийн, Ойн зурвас байгуулах ажилд 16,8 сая төгрөгийн, Суулгацаар ойжуулах төслийн дагуу 2.0 сая төгрөгийн, Цэнгэл сумын "Хулан" нөхөрлөл 5 га, Баяннуур сумын "Дэмжих толгой" нөхөрлөл 10 га, "Заагт" нөхөрлөл 5 га, "Избасар" нөхөрлөл 10 га газрыг мал амьтнаас ойг хамгаалах ажилд 5.9 сая төгрөг нийтдээ 44,2 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

3.3. Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээнд зарцуулсан эсэх талаар.

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгө нь хуулинд заасан хувь хэмжээг хангахгүй байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 2014 онд 37.8 сая төгрөгийн орлого орсоноос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээгээр байгалийн нөхөн сэргээлтэнд 13.2 сая төгрөгийг зарцуулах тооцоо гарч байна.

Тайлант онд Засгийн Газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 3.2.5-д заасан арга хэмжээнд буюу усны эх, булаг шандыг хамгаалах ажлыг "Өмир агаш крафт" ХХКомпаниар гүйцэтгүүлэн 4.0 сая төгрөгийг зарцуулсан ба хуулийн хэрэгжилт 30.3 хувьтай хангалтгүй хэрэгжсэн байна.

2015 онд ус ашигласны төлбөрийн орлогоос 16.4 сая төгрөгийн орлого орсоноос 5.7 сая төгрөгийг нөхөн сэргээлтэнд зарцуулахаар тооцоо гарч байна. Тухайн жилд булаг шандын эх хамгаалахад 2.8 сая төгрөгийг зарцуулж, хуулийн хэрэгжилт 49.1 хувьтай хэрэгжсэн байна.

2015 онд Улаанхус сумын Хүрэн уулын булаг, Бугат сумын Хатуугийн булаг шандыг хашиж хамгаалах ажилд 2,8 сая төгрөг зарцуулж, Засгийн Газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 3.2.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлжээ.

3.4. Байгалийн ургамал, ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.1, 3.4-т заасан арга хэмжээнд зарцуулсан эсэх талаар.

Ан амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогоос нөхөн сэргээлтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулийн заалтыг хангахгүй байна.

Байгалийн ургамлын тухай хуулиар ургамлын нөөцийг мэргэжлийн байгууллагаас тогтоож, үүний дагуу тусгай зөвшөөрөлийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас олгох хуулийн заалттай бөгөөд 2014, 2015 онуудад ургамалын нөөц ашиглах талаар зөвшөөрөл олгогдоогүй байна.

-2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас үйлдвэрийн зориулалтаар Толбо нуураас 20 тн загас агнах зөвшөөрлийг олгож, тухайн жилд 5 тн загас агнаж, төлбөр хураамжинд 4,2 сая төгрөгийн, Булган сумын газар нутгаас зөвшөөрлийн дагуу судалгаа шинжилгээний зориулалтаар агнасан ангийн төлбөрийн хураамжаас 6.6 сая төгрөгийн буюу ангийн нөөц ашигласны орлогоос бүгд 10.8 сая төгрөгийн орлого орсон байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн 2-т заасан хувь хэмжээгээр ангийн орлогын 50 хувь буюу 5.4 сая төгрөгийг нөхөн сэргээлтэнд зарцуулах ёстойгоос тухайн жилд 35.0 сая төгрөгийг Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө хийлгэхэд зарцуулж, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

-БОАЖЯамнаас 2015 онд 5 сумын газар нутгаас тусгай зориулалтаар сумдын 6 нөхөрлөлөөр дамжин 8 угалз, 3 халиун буга агнуулахаар зөвшөөрөл олгосон байна.

Дээрхи зөвшөөрлийн дагуу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу 8 угалз агнасны төлбөр хураамжинд 284.1 сая төгрөгийн, 2 халиун буга агнасны төлбөр хураамжинд 4.6 сая төгрөгийн, үйлдвэрийн зориулалтаар Толбо нуураас агнасан 20 тн загасны төлбөр хураамжинд 17.8 сая төгрөгийн нийтдээ 306.5 сая төгрөгийн орлогыг ангийн нөөц ашигласны төлбөрийн хураамжаас оруулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-ийн 2-т заасан хувь хэмжээгээр 153.2 сая төгрөгийг байгалийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах тооцоо гарч байгаа боловч 2015 онд Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4.2-т заасан амьтны

амьдрах орчныг нөхөн сэргээх, тэтгэх арга хэмжээнд 1.2 сая төгрөгийг зарцуулж, хуулийн хэрэгжилт 0.7 хувьтай буюу хангалтгүй үзүүлэлттэй гарсан байна.

3.5. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөл, болзол, хувь хэмжээг орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу зөв шийдвэрлсэн эсэх талаар.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөлийн дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан аж, ахуй нэгж, байгууллагуудаас 2014 онд 460844,3 метр куб, 2015 онд 459488,5 метр куб усыг хуулийн дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн байна.

Аймгийн ИТХ-д Байгаль орчны газраас 2015 онд санал оруулсны үндсэн дээр аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 36 дугаар тогтоолоор 12 сумын газар нутгаас 50 толгой чоно агнах зөвшөөрөл олгосны дагуу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т зааснаар дагуу ангийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлжээ.

Бүлэг 4

*Ус ашиглуулахтай холбоотой хяналтыг
сайжруулах шаардлагатай байна.*

4.Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоодын хяналт хуульд заасны дагуу хэрэгжиж буй эсэх талаар.

4.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх талаар.

Байгаль хамгаалах хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх зүйн орчин бүрдсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль, Агаарын тухай хууль, Газрын тухай хууль, Хог хаягдлын тухай зэрэг хуулиудын хүрээнд байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ”,

16 дугаар зүйлийн 16.4-д Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” **17 дугаар зүйлийн 17.4-д Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд** “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” Мөн хуулийн 27 дугаар зүйлд Улсын байцаагчийн, 28-зүйлд Байгаль хамгаалагчийн хууль хэрэгжүүлэх эрх үүргийг зааж эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

4.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих дотоод нэгжээс хяналтыг хэрэгжүүлж буй эсэх талаар.

Ус ашиглуулахтай холбоотой хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

БОАЖГазрын мэдээ тайлангаас үзэхэд 2014 онд байгаль орчныг хамгаалах, баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажилд 79 аж ахуйн нэгж, 114 байгууллага, 49197 иргэнийг хамруулж 95 зөрчил илрүүлэн 92 зөрчлийг ондоо багтаан арилгуулж, 10560,0 мянган төгрөгийн торгууль, 7749,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж, 4468,0 мянган төгрөгийн торгууль, нөхөн төлбөрийг хугацаандаа барагдуулжээ.

Илэрсэн зөрчлийн ихэнх нь ой мод, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалттай холбоотой зөрчлүүд байна. Ховд голын ай сав газраас зөвшөөрөлгүй хууль бус хайрга ашигласан 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож, зөрчил гаргасан 4 байгууллагад эрх бүхий байгууллагаар хариуцлага тооцуулах санал тавьж, 1 байгууллагыг мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

-2015 онд байгаль орчныг хамгаалах, баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын ажилд 96 аж ахуйн нэгж, 57 байгууллага, 8000 иргэнийг хамруулж 12 зөрчил илрүүлэн илэрсэн зөрчлийг ондоо багтаан арилгуулах арга хэмжээ авчээ.

Илэрсэн зөрчлүүдтэй холбоотой 17000,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 1344,0 мянган төгрөгийн торгууль тавьж нөхөн төлбөрийн 82,3 хувийг, торгуулийг бүрэн барагдуулж, 3000,0 мянган төгрөгийн барагдаагүй нөхөн төлбөр дараа онд шилжсэн байна.

Зөрчлийн ихэнх хувийг хууль бусаар ан амьтан агнах, ой мод ашиглалттай холбоотой зөрчил эзэлж байна. Нөхөн сэргээлт хийгдээгүй байсан 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож зөрчлийг арилгуулж, зөрчил гаргасан 3 байгууллагад эрх бүхий байгууллагаар хариуцлага тооцуулах санал тавьж, 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

-2016 оны эхний хагас жилийн мэдээгээр байгаль орчныг хамгаалах, баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажилд 34 аж ахуйн нэгж, 16 байгууллага, 4600 иргэнийг хамруулж 5 зөрчил илэрсэнийг арилгуулах арга хэмжээ авч 3906,1 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 1300,0 мянган төгрөгийн торгууль тавьж барагдуулжээ.

МХГазрын тайлангаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийгдсэн төлөвлөгөөт шалгалтанд 2014 онд 67 иргэн, ААН-ийг хамруулан 384 зөрчил илүүлж, 192,0 мянган төгрөгийн торгууль тавьж төсөвт оруулсан байна. Харин 2015 онд 35 нэгжийг шалгалтанд хамруулан 603 зөрчил илрүүлэн 5200,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 2696,0 мянган төгрөгийн торгуулийг барагдуулан 2504,0 мянган төгрөгийн торгуулийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Түүнчилэн 2016 оны эхний хагас жилд төлөвлөгөөт шалгалтанд 64 нэгжийг хамруулан 1046 зөрчил илрүүлэн 18056,0 мянган төгрөгийн торгууль, 1030,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж, 15560,0 мянган төгрөгийн торгуулийг шүүхэд шилжүүлэн, бусад торгууль нөхөн төлбөрийг хугацаандаа барагдуулжээ.

Дээрхи байдлаас үзэхэд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад багц хуулиудын хүрээнд нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хуулийн биелэлтэнд хяналт тавих, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар эрх бүхий

байгууллага, албан тушаалтнууд хууль сурталчилах, хяналт тавих, үйл ажиллагаа хязгаарлах тодорхой ажлуудыг хийж байгаа ч иргэн, аж ахуйн нэгжүүд байгаль хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах талаар хуулиар хүлээсэн эрх үүргээ ухамсарлаагүйгээс хууль зөрчих явдал арилахгүй байна.

Усны тухай хуулийн холбогдох заалтууд зөрчигджээ.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-д “Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”, 28 дугаар зүйлийн 28.6-д “Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ”, 28.11-д “Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ”, 28.18-д “Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно” гэж ус ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг заасан байна.

Гэтэл БОАЖГазрын гаргасан 2014, 2015 оны судалгаагаар аймгийн төвд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй гүний худаг эзэмшигч 24 ус ашиглагч аж ахуйн нэгжүүдээс 2 байгууллага нь зөвхөн 1 жилийн дүгнэлт гаргуулсан, 22 нь ус ашиглах дүгнэлтийг огт хийлгэхгүйгээр ус ашиглаж байгаа ба бүгд тоолуур тавиагүй байна.

Ус ашиглалттай холбоотой зөрчил гарч байгаа шалтгааныг БОАЖГазрын мэргэжилтнээс тодруулахад Усны тухай хуулийн дагуу бид ус ашиглагч иргэн, ААН-үүдэд ус ашиглалттай холбоотой хяналт тавьдаг боловч бидэнд арга хэмжээ авах эрх хэмжээ хязгаарлагдмал, МХГазрын эрх бүхий улсын байцаагчидад хандаж зарим шалгалтыг хийдэг ч тэдний төлөвлөгөөнд ороогүй асуудал хугацаа алдаж хийгддэг асуудал гардаг гэсэн тайлбар өгч байна.

Усны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан эрх хэмжээний хүрээнд аймгийн БОАЖГазар нь усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих, усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх г.м усны нөөц ашиглах, хамгаалахтай холбоотой эрх үүрэгтэй юм.

Хуулийн энэ чиг үүргийн дагуу БОАЖГазар нь ус ашиглалттай холбоотой хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгааг үгүйсгэх аргагүй боловч Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар БОАЖГазрын байгаль хамгаалагч нарт хууль зөрчиж үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-ийн үйл ажиллагааг шууд зогсоох эрх байхгүй, хууль зөрчиж үйл ажиллагаа явуулж буй асуудлыг МХГазрын

улсын байцаагчид мэдээлж арга хэмжээ авхуулах эрх зүйн зохицуулалттай байдаг байна.

Дээрхи байдлыг дүгнэж үзэхэд үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хяналтын чиг үүрэг 2 байгууллагаар дамжин хэрэгждэг тул зарим зөрчлүүд 2 байгууллагын хооронд явж шийдвэрлэгдэхгүй сунжирах, орхигдох асуудал гардаг байна. Иймд хяналтын чиг үүрэг бүхий байгууллагууд хамтарч ажиллах, ажлын уялдаа холбоогоо сайжруулан хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

Аудитын дүнгээс үзэхэд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын байгалийн зарим нөөц ялангуяа ус ашиглалтанд тавих хяналт хангалтгүй, иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрөлгүй авалгүйгээр үйл ажиллагаа явуулж ирсэнээс аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдэд ус ашиглах, бохир зайлуулах дүгнэлт гаргуулах ажилд тавих хяналт хангалтгүй хийгдсэн, Ногооннуур, Өлгий, Цэнгэл сумуудад үйл ажиллагаа явуулж байгаа ус ашиглагч ААН-үүдийн гэрээнд заасан усны төлбөрийг бүрэн төлүүлж аваагүй, хотын төвийн дулааны цахилгаан станц, зарим сумдын халаалтын нэгдсэн зуух зэрэг 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухнууд үнэлгээнд хамрагдаагүй гэх мэт хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа зөрчлүүд байна.

Иймд төвлөрсөн бус ус хангамжаас ус ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдэд Усны тухай хуулийн дагуу холбогдох байгууллагаар хийлгэсэн дүгнэлт, зөвшөөрлийн үндсэн дээр гэрээ хийж ус ашиглуулах, хяналтыг сайжруулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болгов.

Үүнээс гадна хотын төвийн цэвэрлэх байгууламж, хог хаягдлын нэгдсэн нь шаардлага хангахгүй болж шинэчлэх шаардлагатай болсон, аюултай хог хаягдалыг шатаах цэг байгуулах зэрэг төсөв хөрөнгөтэй холбоотой шийдэгдээгүй асуудлууд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс жил бүр тодорхой хэмжээний хөрөнгө төлөвлөн, хэрэгжилтийг хангуулж ирсэн байна.
2. Аймгийн ИТХ, Засаг даргаас байгаль орчныг хамгаалах талаарх хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлж ирсэн боловч аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.6-д, Засаг даргын 16 дугаар зүйлийн 2-ийн 7, 8, 9-д заасан байгаль орчныг хамгаалах талаар бүрэн эрх хангалтгүй хэрэгжсэн байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж чадаагүй байна.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого жил бүр давж биелэгдсэн байна.
5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ хуулинд заасан хувь хэмжээг хангахгүй байна.
6. Аймгийн төсвөөс байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан жил бүр зохих хэмжээний хөрөнгийг БОХСанд төвлөрүүлэн зарцуулж ирсэн байна.
7. Сумууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсвийн урсгал зардалд зарцуулж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4, 18.1 дэх заалтуудыг зөрчиж ирсэн байна.
8. Иргэн, ААН-үүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрөлд тавих хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан танаа:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.6-д заасны дагуу шинээр томилогдсон аймгийн Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг хүлээлгэн өгч, сангийн өөрчлөлтийн тайланг жил бүр хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгч байх.

Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. Сумын төсөвт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос төвлөрч байгаа хөрөнгийн зарцуулалтанд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу хяналт тавьж, орон нутгийн төсвийн урсгал зардалд зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;
2. Аймгийн хэмжээнд ус ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ААН, байгууллагуудын ус ашиглахтай холбоотой дүгнэлт, эрхийн бичиг, зөвшөөрөл, гэрээ, усны мэдээллийн санд орсон эсэхэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч, ус ашиглагч ААН-үүдийн ус ашиглах гэрээний биелэлтийг хангуулах;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2-ийн 7, 8, 9-д заасан эрхийн дагуу байгаль орчныг хамгаалах нөхөрлөлийн ажлыг бүх талаар дэмжиж ажиллах;

Холбогдох байгууллагын санал

.....Багууллагын нэрийг оруулах.....) ирүүлсэн санал:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум,
Утас/Факс: (976) 7042 2657

2016.10.10 № 150
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.БЕКЕН
ТАНАА

Байгаль орчны тухай хуулийн нийцлийн аудит
тайланд дараах санлуудыг тусгаж өгөхийг хүсье.

Үүнд:

1. Аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөг
батлуулах, төлөвлөгөөний дагуу ажиллах гэдгийг нэмэх
2. Ус ашиглах ААН-үүдийн ус ашиглах гэрээний
биелэлтийг хангуулах гэдэг нь тус байгууллагаас гарах
учир хасах
3. Аймгийн БОХСанд хуулийн дагуу мөнгө
төвлөрүүлэх (Жишээ нь Булган аймаг 1 тэрбум төгрөгний
сантай)
4. Ховд явах зам дагуух ойн зурвасын талбайн
хариуцах эзэнгүй байгаа тул Өлгий суманд хариуцуулах
талаар Аймгийн засаг даргын захирамж гаргуулах

Уг тайлан нь хуулийн холбогдох заалтын дагуу үнэн
зөв хийгдсэн болохыг тодорхойлов

ДАРГА  Ш.МАРАТ
9316120610 - 9006974

Тайланг баталгаажуулсан:

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Х.Бекен

Тайланг хянасан:

Аудитын менежер Х.Женисбек

Тайланг бэлтгэсэн :

Ахлах шинжээч К.Риза
шинжээч Ж.Назгүл